

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН НИЙТЛЭГ ШААРДЛАГА

MSN :2024

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

Улаанбаатар хот

2024

Өмнөх үг

Стандарт Хэмжил Зүйн Газар (Цаашид СХЗГ гэх) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд Монгол улсын стандарт боловсруулах ажлыг тус байгууллагын дэргэдэх мэргэжлийн сайн дурын ажлын хэсгээс бүрдсэн техникийн хороодоор дамжуулан гүйцэтгэдэг.

Улсын стандартын төсөл боловсруулах ажлыг холбогдох салбарын техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг бөгөөд техникийн хороодоор хэлэлцэж дэмжсэн, зөвшилцөлд хүрсэн стандартын төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлийн хуралдааны тогтоолоор баталснаар улсын хэмжээнд хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг Н.Баярмаа, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Ж.Азжаргал, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хүүхэд хамгааллын бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, А.Батхишиг (PhD), Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны сургуулийн харьяа Нийгмийн ажлын инновац, туршилт судалгааны төвийн захирал, М.Чанцалсүрэн, Монгол улсын их сургууль, Шинжлэх ухааны сургуулийн харьяа Нийгмийн ажлын инновац, туршилт судалгааны төвийн гишүүн, судлаач, Э.Дуламсүрэн, Хүүхэд хамгааллын зөвлөх, Ренчиндорж, Хуулийн зөвлөх, А.Тайванжаргал, Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн менежер, сэтгэл судлаач, С. Энхтуяа, Хүүхэд хамгааллын зөвлөх, судлаач нар боловсруулсан.

Стандарт үзлэгийг 5 жил тутамд хийх боловч шинжлэх ухаан, техникийн түвшинг дээшлүүлэхээр дахин хянах асуудал хугацааны хувьд нээлттэй байна.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар Ш/Х-48

Утас 266754, 263860 Факс (976-11) 458032

Web: www.estandart.gov.mn

E-mail: standardinform@masm.gov.mn

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн, эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код

Жагсаал, цуглааны үеийн хүүхэд хамгааллын нийтлэг шаардлага	MNS :2024
Standard requirements for child protection during demonstrations and assemblies	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны ... дугаар сарын-ны өдрийн С/ ... дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2024 оны ... дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Зорилго

Монгол улсын нутаг дэвсгэрт тайван жагсаал, цуглаанд хүүхдийн оролцох, аюулгүй байдлаа хамгаалуулах эрхийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах чиглэлээр оролцогч талуудын хүлээх чиг үүрэг, хариуцлага, баримтлах зарчим, хэм хэмжээг тогтоож мөрдүүлэхэд оршино.

2. Хамрах болон хэрэглэх хүрээ

Энэхүү стандарт нь тайван жагсаал цуглаан хийхэд хүүхдийн оролцох болон аюулгүй байдлыг хангах, эрх ашгийг нэн түрүүнд тавих, болзошгүй эрсдэлээс хүүхдийн амь нас, эрүүл мэнд, нэр хүндийг хамгаалахад жагсаал, цуглааныг зохион байгуулагчид, холбогдох чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллага, хууль сахиулах байгууллага зэрэг оролцогч талуудын үйл ажиллагаанд хяналт тавих, зохицуулахад хэрэглэнэ.

3. Норматив эшлэл

Энэ стандартад холбогдох хууль, дүрэм, журам, норм болон дараах стандартаас эш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалаас эш татна. Үүнд:

- MNS 6948:2021, Гамшиг онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага.
- MNS 6949:2021, Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага.
- MNS 6040:2019, Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага.
- MNS 6440:2014, Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага.
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 тоот тушаал. Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам.
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 тоот тушаал. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам.
- Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн Сангийн зөвлөмж. Жагсах эрх чөлөө ба аюулгүй байдал. Хүүхдүүд оролцсон цуглааныг цагдан хянаж зохицуулах нь. 2023 он.

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал 20(1). 1948 он.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт: 21 дүгээр зүйл. 1966 он.
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц: 5 дугаар зүйл. 1965 он.
- Хүүхдийн эрхийн тухай конвенц: 15-р зүйл. 1989 он.
- Хүүхэд хамгааллын тухай хууль. 26-р бүлэг. 2024 он.
- Хөдөлмөрийн тухай хууль. 2021 он.
- Хүүхдийн эрхийн тухай хууль. 2016 он.
- Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль. 2021 он.
- Гэр бүлийн тухай хууль. 1999 он.

4. Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандартад хэрэглэсэн нэр, томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

4.1 Хүүхэд

18 нас хүрээгүй Монгол улсын хүн бүр¹

4.2 Хүүхдийн эрхийн улсын байцаагч

Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэргэшүүлсэн сургалтад хамрагдсан, тухайн чиглэлээр нэгээс доошгүй жил ажилласан, хүмүүнлэгийн болон нийгмийн ухаан, хууль зүйн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн албан тушаалтныг²

4.3 Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч

Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална.³

4.4 Жагсаал, цуглаан зохион байгуулагч

Жагсаал цуглаан зохион байгуулах эрх бүхий Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, эвсэл, төрийн бус байгууллага.⁴

4.5 Цагдаагийн байгууллага

Нийгмийн хэв журам хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагыг.⁵

4.6 Цуглаан

Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг⁶

4.7 Жагсаал

Иргэд хот суурины гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг⁷

4.8 Тайван жагсаалд цуглаанд хүүхэд оролцох эрх.

Тайван жагсаал, цуглаанд хүүхдүүд эцэг эх болон бусад насанд хүрсэн хүмүүстэй хамт

¹ Хүүхэд хамгааллын тухай хууль 2024 он

² Хүүхдийн эрхийн тухай хууль. (20.3) 2016 он.

³ Гэр бүлийн тухай хууль. (25.3). 1999 он.

⁴ Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль. 1994 он.

⁵ Цагдаагийн албаны тухай хууль. 2017 он.

⁶ Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль 1994 он.

⁷ Мөн тэнд

оролцохоос гадна тэднээс тусдаа хувиараа, бүлгээрээ оролцох эрхтэй.⁸

4.9 Тайван жагсаалд цуглаанд оролцох хүүхдийн эрхийг хязгаарлах.

Хүүхдийн тайван жагсаал, цуглаанд оролцох эрхийг хэрэгжүүлэхэд хориг тавихгүй бөгөөд гагцхүү үндэсний болон нийгмийн аюулгүй байдал, дэг журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хуульд нийцүүлэн тогтоосон хязгаарлалтаас өөр хязгаарлалт тогтоож болохгүй.

4.10 Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги

Жагсаал цуглаан тайван бус жагсаал цуглаан болж хувирах үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, төөрсөн, эцэг эх нь олохгүй байгаа хүүхдийг хүүхдийг эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, нэрвэгдсэн хүүхдүүдэд эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсрол, нийгмийн халамж болон хүмүүнлэгийн дэмжлэг үзүүлэх хүч хэрэгсэл.⁹

4.11 Аюулгүй байдал

Аюул, осол, эрсдэл, гэмтэл бэртлээс хамгаалагдах нөхцөл байдал, бие махбод, хүрээлэн буй орчин, нийгэм, оюун санаа, улс төр, сэтгэл зүйн хохирлоос ангид байх хүүхдийн бие махбодын, хувь хүний сайн сайхан, бүрэн бүтэн байдалд¹⁰

4.12 Аюулгүй орон зай

Хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн нийгэм сэтгэл зүйн сайн сайхан байдлыг дэмжин зорилгоор хүмүүнлэгийн байгууллагын хэрэглэдэг арга хэмжээ.¹¹

4.13 Хүүхэд хамгаалал

Нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг;¹²

4.14 Хүүхдийн эсрэг хүчирхийлэл

Хүүхдийн хэвийн өсөлт, хөгжил, эрүүл мэнд, аюулгүй байдалд хор хохирол учруулах, бие махбод, сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн дарамт, хүчирхийллийн үйлдэл, эс үйлдэхүйг;¹³

5. Үндсэн зарчмууд:

5.1. Хүүхдийн дээд эрх ашиг: Тайван жагсаал цуглааны үеэр авах аливаа арга хэмжээ нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нь нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэнэ. Энэ нь болзошгүй эрсдэлийг үнэлэх, жагсаал, цуглааны бүх үйл ажиллагаа, арга хэмжээ нь хүүхдийн бие махбод, сэтгэл зүйн сайн сайхан байдалд хор хөнөөл учруулахгүй байх явдал юм.

5.2. Хүчирхийллээс хамгаалах: Хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагууд жагсаал, цуглааны үед хүүхдийг гэмтэл бэртэл, хүчирхийлэл, дарамтаас хамгаалах ёстой бөгөөд хүүхэдтэй холбоотой нөхцөл байдалд анхаарал, мэдрэмжтэй хандахад цагдаагийн албан хаагчдыг чадавхжуулна.

⁸ ХЭК-ийн 15-р зүйл. 1989 он.

⁹ MNS 6949:2021 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын стандарт. 2021 он.

¹⁰ Мөн тэнд

¹¹ Мөн тэнд

¹² Хүүхэд хамгааллын тухай хууль. 2024 он.

¹³ Мөн тэнд

5.3. Оролцох эрх: Хүүхдүүд өөрт хамаатай асуудал, тэр дундаа тайван цуглаанд оролцох зэрэг асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй. Төрийн байгууллагууд хүүхдийн аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ хүүхдийн жагсаалд цуглаанд оролцох эрхийг хэрэгжүүлнэ.

5.4. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх: Нийгмийн байдал, нөхцөл байдлаас үл хамааран бүх хүүхдэд ижил тэгш хамгаалалт, эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгоно.

6. Ерөнхий шаардлага

6.1. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭК): Оролцогч улсууд эвлэлдэн нэгдэх, тайван замаар хуран цуглах хүүхдийн эрх (15 дугаар зүйл), болон тусгай хамгаалалтад авах эрхийг (19 дүгээр зүйл) хүлээн зөвшөөрдөг. Эдгээр эрх нь тэнцвэртэй байх ёстой төдийгүй хүүхдийн аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ тайван жагсаал, цуглаанд оролцох эрхийг нь хүндэтгэнэ.

6.2. Хууль сахиулахын байгууллагын албан хаагч хүч хэрэглэх тухай НҮБ-ын удирдамж¹⁴ нь зөвхөн онц шаардлагатай үед, аюул заналхийлэлтэй хувь тэнцүүлэн хүч хэрэглэх ёстойг онцолсон. Хүүхэдтэй харьцахдаа цагдаагийн байгууллага хор хөнөөл учруулахгүйн тулд нэмэлт урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

6.3. Цагдаагийн байгууллага нь нийгмийн хэв журмыг хамгаалах чиг үүргийн хүрээнд хуульд заасан журмын дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалж, түүнд оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах үүрэгтэй.

6.4. Олон нийтийг хамарсан жагсаал, цуглааны үед хүүхдийг эрсдэлт нөхцөлд орох, осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх үүргийг зохион байгуулагч болон оролцогч талууд хүлээнэ.

7. Хүүхдийг хамарсан жагсаал, цуглааныг зохион байгуулах, хянах үйл ажиллагааг аюулгүй явуулах, хүүхдийн эрхийг хүндэтгэх зорилгоор төрийн байгууллагын үүрэг, хариуцлага.

7.1 Жагсаал цуглааны үед хүүхдийн эрхийг хүндэтгэх, хамгаалахын тулд хүүхдийн эрхийн улсын байцаагч, болон цагдаагийн албан хаагчдын хүлээх үүрэг, хариуцлага:

7.1.1 Жагсаал, цуглааны үед хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хангана.

7.1.2 Хүүхдийн оролцоог хангахын тулд зохих харилцаа холбоо, дэмжлэг үзүүлнэ.

7.1.3 Хүүхдэд хүч хэрэглэх, тэднийг ялгаварлан гадуурхахаас хамгаална.

7.1.4 Хүүхдийн жагсаал, цуглаанд насанд хүрэгчидтэй адил тэгш эрхтэйгээр, ямар нэг хязгаарлалтгүйгээр оролцох эрхийг хүндэтгэнэ.

7.2 Жагсаал цуглааны үед хүүхдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах үүднээс асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон цагдаагийн байгууллагын удирдлагууд дараах хариуцлагыг хүлээнэ.

7.2.1 Бэлтгэл, сургалт: Цагдаагийн байгууллагын ажилтан, албан хаагчид жагсаал, цуглааны үед хүүхдийн эрх, хүүхэдтэй харилцах зөв арга зүйн талаар сургалтад заавал хамрагдана.

7.2.2 Эрсдэлийн үнэлгээ: Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги, хүүхдийн эрхийн байцаагч, жагсаал цуглаан зохион байгуулагчид хамтран жагсаал, цуглаан эхлэхээс өмнө эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийж, хүүхдэд учирч болзошгүй аюулыг

¹⁴ Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн Сангийн зөвлөмж. Жагсах эрх чөлөө ба аюулгүй байдал. Хүүхдүүд оролцсон цуглааныг цагдан хянаж зохицуулах нь. 2023 он.

тодорхойлж, үүний дагуу төлөвлөнө. Жагсаал цуглааны үед гардаг аливаа сөрөг үзэгдлээс бага насны хүүхдийн хүмүүжил, ёс суртахууныг хамгаалахад нэн түрүүнд анхаарна.

7.2.3 Пропорциональ /хувь тэнцүүлсэн хариу арга хэмжээ: Хүч хэрэглэх эсхүл албадан саатуулах нь эцсийн арга хэмжээ байх ба энэ нь аюул заналхийлэлтэй пропорциональ байх ёстой бөгөөд хүүхэд байгаа эсэхийг нэн түрүүнд анхаарч үзнэ.

7.2.4 Нээлттэй харилцаа: Хүүхдүүдэд өөрсдийн эрх, цагдаагийн байгууллагаас хүлээгдэж буй зан үйлийн талаар жагсаал, цуглаан хийх үеэр мэдээлэх үүрэгтэй. Үүнд шаардлагатай тохиолдолд хэрхэн тусламж хүсэх тухай мэдээлэл орно.

7.2.5 Хяналт, хариуцлага: Хүүхэд хамгааллын стандартын хэрэгжилтийг хангах үүднээс хүүхэд оролцсон цуглааны үеэр бие даасан байгууллагууд хуулийн хэрэгжилтэд хяналт тавина. Аливаа зөрчлийг шалгаж, буруутай хүмүүст хариуцлага тооцно.

8. Хүүхдийн тайван жагсаал цуглаанд оролцох эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх

8.1 Эрхийг хүндэтгэх:

8.1.1 Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагууд хүүхдийн аюулгүй орчныг бүрдүүлж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах замаар хүүхдийн тайван жагсаалд оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.

8.2 Эрхийг хамгаалах:

8.2.1 Жагсаал, цуглааны үеэр хүүхдэд зориулсан аюулгүй орон зайг тогтоосон байна.

8.2.2 Шаардлагатай тохиолдолд хүүхдэд туслах хүүхдийн эрхийн улсын байцаагч, эсхүл хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан байна.

8.2.3 Хүчирхийлэл, эмх замбараагүй байдлын үед хүүхдийг хохироохоос хамгаалах шуурхай арга хэмжээ авах протокол хөтөлнө.

8.3 Эрхийг хэрэгжүүлэх:

8.3.1 Хүүхдэд ээлтэй бүс: Бэлтгэгдсэн боловсон хүчний хяналт, дэмжлэгтэйгээр хүүхдийн аюулгүй оролцох боломжтой бүсүүдийг бий болгоно.

8.3.2 Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоо: Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг нэмэлт дэмжлэг, хамгаалалт үзүүлэхийн тулд цугларалтад хүүхдүүдийг дагалдан явуулахыг дэмжинэ.

8.3.3 Гамшиг, онцгой байдлын тусгай стандартууд: Жагсаал, цуглааны үеэр нөхцөл байдал хүндэрч онц байдал бий болж үед хүүхдийг нүүлгэн шилжүүлж, хамгаална.

8.3.4 Боловсрол, нөлөөлөл, олон нийтийн кампанит ажил: Сургууль, олон нийтийн төв, нийгмийн сүлжээ, цахим орчинд хүүхдүүдэд өөрсдийн эрх, цуглааны үеэр хэрхэн аюулгүй байх талаар мэдээлэл өгнө.

9. Тайван жагсаал цуглаан зохион байгуулах үйл ажиллагаанд тавигдах шаардлага:

9.1 Тайван жагсаал цуглааны өмнө: Бэлтгэхэд тавигдах шаардлага

9.1.1 Эрх эдлэгчийн хувьд хүүхдийн тайван жагсаал цуглаанд оролцох эрхээ хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх. Бүх хүүхэд тайван жагсаал цуглаанд оролцох эрхийн талаар сургуульд болон олон нийтийн боловсролоор дамжуулан суралцах ёстой. Жагсаал, цуглаан зохион байгуулагчид хүүхдэд жагсаал цуглааны мэдээлэл, хүүхдийн оролцох эрхийн талаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт

тохирсон, ойлгоход хялбар, хүүхдэд ээлтэй, жендэрийн болон соёлын ялгааг харгалзан үзсэн байна. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, эрсдэлт нөхцөлд буй хүүхдүүд, үндэстний цөөнхийн хүүхдүүд, алслагдсан бүс нутагт амьдардаг хүүхдүүд, интернэтэд холбогдох боломжгүй хүүхдүүдэд хүрэх ёстой.

- 9.1.2** *Үүрэг хүлээгчдийн хувьд насанд хүрээгчдийг хүүхдийн тайван жагсаал цуглаанд оролцох эрхийг талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх.* Хүүхдийн эрхийн талаарх хариуцлага хүлээгч нь төрийн байгууллагын ажилтнууд, цагдаагийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн багш нар, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид юм. Тэд хүүхдийн тайван жагсаал, цуглаанд оролцох болон аюулгүй байдлаа хамгаалуулах эрхүүдийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх хууль ёсны үүрэгтэй.
- 9.1.3** *Мэдээллийг хүртээмжтэй болгох.* Цагдаагийн албан хаагчид болон жагсаал зохион байгуулахад оролцож буй бусад насанд хүрэгчид хүүхдүүдэд тайван жагсаал зохион байгуулах, оролцохтой холбоотой хууль тогтоомж, журам, үүнтэй холбоотой хориглох заалт, хязгаарлалтуудыг ойлгомжтой, хүүхдэд ээлтэй, насанд нь тохирсон, хүйсийн мэдрэмжтэй байдлаар тайлбарлана. Цагдаагийн албан хаагчид болон холбогдох бусад хүмүүс хүүхдүүдийг юу хүлээж байгааг, оролцооны ашиг тус, эрсдэлүүдийг ойлгуулахад тусалж, тэдэнд мэдээлэлтэй шийдвэр гаргах боломжийг олгох ёстой бөгөөд сүрдүүлэх, айлган дарамтлах үйлдэл байх ёсгүй.
- 9.1.4** *Шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх.* Боловсролын яам, бүх шатны боловсролын байгууллагуудтай хамтран тайван жагсаал цуглаанд оролцохын ашиг тус, эрсдэлийн талаарх мэдээллийг хэлэлцэх боломжийг хүүхдэд өгч тэднийг мэдээлэлтэй шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлнэ.
- 9.1.5** *Хууль эрх зүйн болон журмын саад бэрхшээлийг арилгана.* Хүүхдийн тайван жагсаал цуглаанд оролцох эрхийг дэмжихээс гадна хууль эрх зүйн болон журмын саад бэрхшээлийг арилгаснаар цагдаагийн байгууллагын албан хаагчдад болох гэж буй жагсаал, цуглааны талаар чухал мэдээлэл авахад тусална.
- 9.1.6** *Харилцаа, хандлага.* Хууль сахиулах байгууллага болон бусад холбогдох мэргэжлийн байгууллага нь жагсаал цуглаанд хүүхэд оролцохтой холбоотой дүрэм журмыг хүүхдэд ойлгомжтой, энгийн боловсруулж, дагаж мөрдөнө.
- 9.1.7** *Цагдаагийн албан хаагчдыг мэдлэг, ойлголт, хандлагыг сайжруулах.* Цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүн болон холбогдох албан тушаалтнуудыг хүүхдүүдийн эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлэх зорилгоор тэднийг хүүхдүүдтэй холбоотой жагсаалд оролцоход зохих ёсоор бэлтгэнэ. Цагдаагийн албан хаагчид хүүхдийн тайван жагсаал, цуглаанд оролцох, шийдвэр гаргах чадварыг сулруулж болзошгүй сөрөг яриа хэлэлцүүлэг, үүнд төрийн албан тушаалтнуудын хэлсэн үгэнд мэдрэмжтэй хандана.
- 9.1.8** *Урьдчилан сэргийлэх арга хэмжээ.* Жагсаал цуглаан эмх замбараагүй байдалд шилжвэл өөрийгөө болон үе тэнгийнхнийхээ хэрхэн хамгаалах талаар холбогдох хууль тогтоомж, ХЭК-ийн заалтыг хүүхдэд ойлгомжтой хэлээр, тэдэнд хүртээмжтэй газар болон нийгмийн сүлжээнд байршуулан хүүхдийн эрхийн зөрчил даамжрахаас урьдчилан сэргийлнэ.
- 9.1.9** *Хүүхдийн оролцоог дэмжих.* Хүүхдийн оролцооны байгууллагуудаар дамжуулан тайван жагсаал, цуглаан, мэтгэлцээн зохион байгуулах, насанд хүрэгчдийн зохион байгуулж буй жагсаалд нэгдэх замаар хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэх боломжийг бүрдүүлнэ. Жагсаал цуглаан болж буй газрын ойролцоо өсвөр насны хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлж үе тэнгийнхэнтэйгээ уулзаж ярилцах боломжийг

бүрдүүлэн байна. Хүүхдүүд байгаа газраасаа цахимаар оролцох боломжтой байна.

- 9.1.10** Хүүхдэд мэдээлэл өгөх цэг. Тайван жагсаал цуглаан үед хүүхэд жагсаал цуглааны мэдээлэл, жагсаал цуглааны нөхцөл байдал өөрчлөгдөх үед хэрхэн, хэнд хандаж хамгаалалт авах талаар заавар өгөх цэг байршуулж, орох гарах гарц тэмдэглэгээг хүртээмжтэй байршуулна.

9.2 Тайван жагсаал цуглааны үед тавигдах шаардлага

- 9.2.1** *Цагдаагийн байгууллагын талаарх хүүхдийн ойлголт.* Хүүхдүүдийн жагсаалд оролцсон туршлага нь тэдний цагдаагийн албан хаагчдыг хэрхэн ойлгодгоос ихээхэн хамаардаг тул харилцан адилгүй байдаг. Тиймээс цагдаагийн ажилтан, албан хаагчдын талаарх эерэг хүүхдийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэхэд анхаарна.

- 9.2.2** *өгөх.* Тайван жагсаалд хүүхэдтэйгээ оролцож байгаа гэр бүлд хүүхдээ хамгаалах, чадавхжуулах үүргээ биелүүлэхэд нь сургуулийн болон байгууллагын эцэг эхийн зөвлөл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зөвлөгөө, мэдээлэл өгнө.

- 9.2.3** *Хүүхдийн хувийн мэдээлэл.* Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй (ХЭК 16). Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (2021) -д заасан мэдээллүүд хамаарна.

- 9.2.4** *Жагсаал, цуглааныг албадан тараах.* Жагсаал, цуглааны явцад нийгмийн хэв журам зөрчигдөх, эмх замбараагүй байдал бий болсон үед мэргэжлийн ангийн дарга нь гэнэт үүссэн нөхцөл байдалд шуурхай хариу арга хэмжээ авч нэмэлт хүч хэрэгсэл дайчилна.

- 9.2.5** *Хүүхдийг аюулгүй орон зайд авчрах.* Жагсагчид шахалдах, мод чулуу, төмөр гэх мэт хатуу зүйл шидэх, нулимс асгаруулагч, тэсэрч дэлбэрэх бодис ашиглах зэргээр хүүхдийн амь нас, эрүүл мэндэд эрсдэл оруулж болзошгүй үед жагсаал, цуглаанаас тэднийг аюулгүй гаргах талаар цагаан хоолойгоор мэдээлэл цацаж аюулгүй орон зайд авчрах, гэр бүлд нь хүлээлгэж өгөх ажлыг цагдаагийн албан хаагчидтай хамтран гүйцэтгэнэ.

- 9.2.6** Жагсаал цуглаан дээр хүүхэд төөрсөн, тайван бус нөхцөл үүссэний улмаас хүүхдүүдийг аюулгүй газар яаралтай шилжүүлэх хэрэгцээ үүссэн үед тэднийг түр байрлуулах хүүхдэд ээлтэй орон зайг Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний автобусыг ашиглах, гэр барих, ойролцоох барилга байгууламжид өрөө түрээслэх зэргээр шийдвэрлэнэ. Аюулгүй орон зай нь олж очиход хялбар ялгах тэмдэг бүхий хаягтай, хүүхэд хүлээн авч бүртгэх ажилтантай, хүйтний улиралд халаалттай байна. Энэ орон зайд хүүхэд саатуулах тоглоом, ном, зурагт зэргийг байрлуулж сайн дурын ажилтнуудыг хүүхдэд нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх ажилд дайчилна.

- 9.2.7** Аюулгүй орон зайд хүргэгдэж ирсэн хүүхдийг бүртгэж эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийг нь олох ажлыг яаралтай хийж гарын үсэг зуруулан хүлээлгэж өгнө. Аюулгүй орон зайд нэг хүүхдийг 6 цаг хүртэл байлгаж эцэг эх нь ирж аваагүй бол түр хамгаалах байр руу шилжүүлнэ. (Хүүхдэд мэдээлэл өгөх цэг байршуулах, ХЭҮК -ийн тайланг харах)

- 9.2.8** Жагсаал цуглаан дээр ээлжээр ажиллаж байгаа мэргэжлийн ангийн гишүүд, сайн дурынхан Аюулгүй орон зай дээр ээлж хүлээлцэх бөгөөд дараагийн хүндээ

нөхцөл байдлыг танилцуулж, мэдээлэл солилцож, тэнд байгаа хүүхдүүдийг бүртгэлээр нь хүлээлгэж өгнө.

9.2.9 Тайван жагсаал цуглаан үймээн самуунд шилжсэн үед хүүхдүүдийг бүлэглэн яллах, санамсаргүй сонгон баривчилж саатуулах зэрэг нь ХЭК-ийн 37 дугаар зүйлийн "б"-д заагдсан хүүхдийн эрх чөлөөг хууль бусаар, дур мэдэн хязгаарлаж болохгүй гэсэн заалтыг зөрчихөд хүргэнэ гэдгийг хууль сахиулах байгууллагынханд таниулна.

9.3 Тайван жагсаал, цуглааны дараа тавигдах шаардлага

9.3.1 Хүүхдийг ялгаварлан гадуурхалтаас хамгаалах. Жагсаал цуглааны дараа Цагдаагийн байгууллагын зүгээс жагсаал цуглаан зохион байгуулагчид, оролцогчид болон иргэний нийгмийн байгууллагуудыг урьж оролцуулан “Жагсаал цуглааны дүгнэлтийн хийх уулзалтыг тогтмол зохион байгуулна. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалахын тулд төрийн болон улс төрийн албан тушаалтнуудын заналхийлэл, сүрдүүлэг, дарамт шахалт, болон өөрийнх нь гэр бүл, багш, найз нөхөд болон бусад хүнээс ирэх сүрдүүлэг, дарамт шахалтаас хүүхдийг хамгаалахын тулд бүхнийг хийнэ. Бүх шатны сургуулиудад хүүхдийн тайван жагсаалд оролцох сонголтыг эрхэмлэж, тайван жагсаалд оролцохтой холбоотой бодлого боловсруулахдаа сурагчидтай зөвлөлдсөн байна.

9.3.2 *Мэдээлэл, гомдлыг шийдвэрлэх.* Жагсаал цуглааны үед болон дараа хүүхдийн эрх зөрчигдсэн тухай гомдол гаргах механизмыг бүрдүүлж, хохирсон хүүхдэд туслалцаа үзүүлэх, хохирлыг барагдуулах, нөхөн сэргээх арга хэмжээ авна. Гомдлыг Хүүхдийн утас 108 утсаар хүлээн авч шуурхай шийдвэрлэх арга зүйг утасны операторуудад өгнө.

9.3.3 *Хүүхдийг баривчлан саатуулах.* Хүчирхийлэл үйлдсэн гэж тодорхой үндэслэлээр сэжиглэгдэж байгаа хүүхдийн хэргийг Хүүхдийн эрхийн тухай конвенцын 37, 40 дүгээр зүйлүүд болон ХЭК-ийн Хүүхдийн шүүхийн талаарх 24-р тусгай зөвлөмжид зааснаар хүүхдийн шүүхийн үйл явцын дагуу шийдвэрлэхэд үнэ төлбөргүй өмгөөлөгчтэй холбох, мөрдөн байцаалтын үед хамт байлцах нийгмийн ажилтныг томилох зэргээр шийдвэрлэхэд нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

10. Хориглох зүйл заалт

10.1 Хүүхдийг төрийн болон хэсэг бүлгийн тэмцэлд ашиглахыг хориглоно. Үүнд эцэг, эх, асран хамгаалагч нар бага насны хүүхдийг авч өлсгөлөн зарлах, улс төрийн суулт хийх зэрэг хамаарна.

10.2 Жагсаал, цуглааныг цагдаа, дотоодын цэргийн хүчээр албадан тараахад хүүхдийн амь нас, бие махбод, эрүүл мэнд, сэтгэл зүйн хувьд дарамт үзүүлэх, хохирол учруулахыг хориглоно.

10.3 Тайван жагсаал цуглаанд хүүхдээ дагуулж ирсэн эцэг эхийг буруутгах, шийтгэх арга хэмжээг төрийн байгууллага авахыг хориглоно.